

2025 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

**Эрх олгох болон сонирхлын зөрчилтэй хэлцэл
хийх зөвшөөрөл олгох тухай**

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “Банк” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.20 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Монгол Улсын Засгийн газраас 2013 оноос эхлэн хэрэгжүүлж буй ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд иргэдэд олгосон орон сууцны зээлийг багцлан худалдаж байх эрхийг Банкны Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.

2. Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлд заасны дагуу Монголын ипотекийн корпораци ОССК ХХК, түүний охин компани болох Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор үүсгэн байгуулагдсан эсхүл ирээдүйд үүсгэн байгуулагдах тусгай зориулалтын компаниуд болон шаардлагатай бусад хуулийн этгээдүүдтэй сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байгуулах, холбогдох баримт бичигт Банкныг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох этгээдэд дамжуулан итгэмжлэл олгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.

3. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн 3 (гурав) жилийн хугацаанд дагаж мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА